



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/193

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”-ийн 3.2.4, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн “Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээ шинэчлэн батлах тухай” А/169 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. “Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулахад баримтлах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталж, 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

Хоёр. Батлагдсан журмыг мөрдөн ажиллахыг аймаг, дүүрэг (нийслэл)-ийн нийгмийн даатгалын хэлтэс (газар)-ийн дарга нарт, мэргэжил, арга зүйгээр ханган ажиллахыг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар (Ц.Ганцэцэг), сайн дурын даатгалын програм хангамжийг шинэчлэн аймаг, дүүргийн хэлтсүүдэд нэвтрүүлэх, цаашид хөгжүүлж ажиллахыг Мэдээллийн технологийн төв (Г.Хүрэлбаатар), шимтгэл төлөлтийг бүртгэж тооцоо хийх, тайлагнахыг Санхүү бүртгэлийн газар (Б.Даваахүү), журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Д.Ганзориг)-т тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга (Г.Саран)-д даалгасугай.

Дөрөв. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар баталсан “Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулахад баримтлах журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА




Д.ЗОРИГТ





НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР


НИЙГМИЙН ДААТГАЛД САЙН ДУРААР
ДААТГУУЛАХАД БАРИМТЛАХ ЖУРАМ

Баримт бичгийн дугаар: ЖРМ-БХСГ -2020

Баталсан: НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА  Д.ЗОРИГТ

Хянасан: БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ,
СУДАЛГААНЫ ГАЗРЫН ДАРГА  Ц.ГАНЦЭЦЭГ

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ,
СУДАЛГААНЫ ГАЗРЫН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН  С.ЛХАГВАДОРЖ

Боловсруулсан: БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ,
СУДАЛГААНЫ ГАЗРЫН
МЭРГЭЖИЛТЭН  Ж.НАРМАНДАХ

МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН ТӨВИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ц.НАРМАНДАХ

Эх хувь	
Хяналттай хувь	
Хуулбар ба хяналттай хувь	
Хүчингүй хувь	
Хяналтгүй хувь	

АГУУЛГА

1. Зорилго
2. Хамрах хүрээ
3. Хамаарах талууд
4. Баримт бичгийн хариуцагч
5. Сайн дурын даатгалд хамрагдах даатгуулагч
6. Сайн дураар даатгуулсан тухай гэрээ байгуулах, шинэчлэх
7. Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах үйлчилгээг цахимаар үзүүлэх
8. Даатгуулагчийн шимтгэл ногдуулан төлөх сарын хөдөлмөрийн хөлс, орлогын хэмжээ, шимтгэл төлөх хувь хэмжээ, хугацаа
9. Шимтгэл төлөлтийн тооцоог мэдээллийн санд бүртгэх, илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох, нийгмийн даатгалын дэвтэрт бичиж баталгаажуулах
10. Даатгуулагчийн шимтгэл ногдуулан төлж буй сарын хөдөлмөрийн хөлс, орлогын хэмжээ, шимтгэл төлөх хувь хэмжээ, хугацаанд өөрчлөлт оруулах
11. Сайн дураар даатгуулсан тухай гэрээ байгуулахад бүрдүүлэх баримт бичиг
12. Гэрээний хугацааг сунгах, дуусгавар болгох, цуцлах, хүчингүйд тооцох
13. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих
14. Маргаан шийдвэрлэх
15. Нийгмийн даатгалын тухай хууль болон энэ журмыг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

Нийгмийн даатгалын ерөнхий
газрын даргын 2020 оны 09 дүгээр сарын
07-ны өдрийн А/93 дүгээр тушаалын
Хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛД САЙН ДУРААР ДААТГУУЛАХАД БАРИМТЛАХ ЖУРАМ

НЭГ. Зорилго

1.1. Энэ журмын зорилго нь Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах, гэрээ байгуулах, шимтгэлийг төлүүлэх, гэрээний хугацааг сунгах, дуусгавар болгох, шилжилт хөдөлгөөн хийх, эдгээр үйлчилгээг цахимаар үзүүлэх, тооцоо хийх, тайлан гаргах, мэдээллийн цахим санд бүртгэх, баталгаажуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. Хамрах хүрээ

2.1. Энэхүү журмын хамрах хүрээ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 5 дугаар зүйл, 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйл, мөн зүйлийн 3.6 дахь хэсэг, Засгийн газрын 1994 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам”, 2019 оны “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 485 дугаар тогтоолын дагуу нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчид байна.

ГУРАВ. Хамаарах талууд

3.1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газар, Санхүү бүртгэлийн газар, Хяналт шалгалтын газар, Дотоод аудит, мониторингийн газар, Тамгын газрын Үйл ажиллагаа хөгжүүлэлтийн хэлтэс, Мэдээллийн технологийн төв, аймаг (нийслэл), дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс (газар), тасаг, сумын байцаагч.

ДӨРӨВ. Баримт бичгийн хариуцагч

4.1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газар.

ТАВ. Сайн дурын даатгалд хамрагдах даатгуулагч

5.1. Нийгмийн даатгалын сайн дурын хэлбэрт дараах иргэн /цаашид “даатгуулагч” гэх/ хамаарна:

5.1.1. Нийгмийн даатгалд албан журмаар даатгуулснаас бусад тодорхой хөдөлмөр эрхлээгүй, түүнчлэн хувиараа хөдөлмөр эрхлэгч, хувиараа тээвэр хийдэг

жолооч, бичил уурхай эрхлэгч, газар тариалан эрхлэгч (ногоочин), малчин, оюутан, ажилгүй иргэн, тахир дутуугийн тэтгэвэр авагч, захиргааны цалингүй нэг ба түүнээс дээш сарын чөлөө авсан зэрэг Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн;

5.1.2. Гадаад улс оронд ажиллаж, амьдарч байгаа Монгол улсын иргэн;

5.1.3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан “Хүүхдээ 3 нас хүртэл асрах чөлөөтэй байгаа, хүүхдээ төрүүлэхээс өмнө сайн дурын даатгалд хамрагдаж, тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүссэн эх;

5.1.4. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан “Хүүхдээ 3 нас хүртэл асрах чөлөөтэй байгаа, тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүсээгүй эх.

Зургаа. Сайн дураар даатгуулсан тухай гэрээ байгуулах, шинэчлэх

6.1. Энэ журмын 5.1.1, 5.1.2-т заасан даатгуулагч нь нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах тухай хүсэлтээ харьяалах нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-д өөрийн биеэр ирж, эсхүл гар утасны “Нийгмийн даатгал” аппликэйшн, вэб програм ашиглан цахим /цаашид “цахимаар” гэх/-аар хандан хүсэлт гаргаж, эхний сарын шимтгэлээ төлсөн тохиолдолд уг хүсэлтийг нь үндэслэн, тухайн даатгуулагчтай “Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээ”-г байгуулна.


6.2. Энэ журмын 5.1.3, 5.1.4-т заасан даатгуулагч эх нь амаржсан сараас хойш хүүхдээ 3 нас хүртэл асрах чөлөөтэй байх хугацаанд нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах тухай хүсэлтээ хүүхдээ 3 нас хүрээгүй байхад харьяалах аймаг, сум, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-д гаргаж, эхний сарын өөрөө хариуцан төлөх шимтгэлийг төлсөн тохиолдолд тэдгээр эхтэй Засгийн газрын 1994 оны 212 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан журмын “В¹”, “В²”, “В³” дахь заалтыг үндэслэн хүүхдийг нь 3 нас хүртэлх хугацаагаар Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 5 дугаар зүйлд заасны дагуу “Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээ”-г байгуулна.

6.3. “Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээ”-нд гэрээний үргэлжлэх хугацаа, даатгуулагчийн өөрөө мэдүүлсэн шимтгэл төлөх сарын хөдөлмөрийн хөлс, орлого, түүнээс тооцон сар бүр төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ болон дүнг тодорхой тусгана.

6.4. Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь гэрээг даатгуулагчийн төлсөн шимтгэл нь нийгмийн даатгалын сангийн харилцах дансанд орсон уг сарын 01-ний өдрөөс эхлэн шинээр байгуулсанд тооцно.

6.5. Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь батлагдсан маягтын дагуу даатгуулагчтай байгуулсан гэрээг цахим системээс 2 хувь хэвлэж, хэлтсийн эрх бүхий албан тушаалтнаар батлуулж, нийгмийн даатгалын байцаагч, даатгуулагч нар гарын үсэг зурж (эсвэл даатгуулагчийг биеэр ирсэн үед нь) баталгаажуулна.

6.6. Хүүхдээ төрүүлэхээс өмнө нийгмийн даатгалд сайн, дурын хэлбэрээр даатгуулж, жирэмсэн, амаржсаны тэтгэмж авах эрх үүссэн эх нь амаржсаны дараа



хүсэлт гаргасан тохиолдолд түүний гэрээг энэхүү журмын 6.2-т заасан хэлбэрээр шинэчлэн байгуулна.

Долоо. Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах үйлчилгээг цахимаар үзүүлэх

7.1. Энэ журмын 5.1-д заасан даатгуулагч нь нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах гэрээ байгуулах, гэрээ сунгах, шимтгэлийн төлбөр төлөх, шилжилт хөдөлгөөн хийх үйлчилгээг цахимаар авч болно.

7.2. Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах гэрээг цахимаар байгуулах, сунгах иргэн нь нийгмийн даатгалын цахим системд өөрийгөө таниулан бүртгүүлэх, баталгаажуулах үйлдлийг заавал хийсэн байна. Энэхүү цахим систем нь иргэний "Иргэний үнэмлэх"-ийн мэдээллийг агуулсан, тухайн даатгуулагчийг хэлтэс, байцаагч дээр биеэр нь ирүүлэлгүйгээр таних боломжийг бүрдүүлсэн байна.

7.3. Энэ журмын 7.2-т заасны дагуу мэдээллээ баталгаажуулсан иргэн уг системээс өгөгдсөн нэвтрэх нэр, нууц үгийг ашиглан сайн дурын даатгалын үйлчилгээг цахимаар үзүүлэх системд нэвтэрч энэ журмын 7.1-д заасан үйлчилгээг авна.

7.4. Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах гэрээг цахимаар байгуулах, гэрээгээ сунгах иргэн нь гэрээний заалтуудыг урьдчилан танилцсаны үндсэн дээр өөрийн ажил эрхлэлтийн байдал, сайн дураар даатгуулах хугацаа, шимтгэл төлөх сарын хөдөлмөрийн хөлс, орлого зэргээ өөрөө зөв тодорхойлж, хүсэлтээ харьяалах аймаг, сум, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-д илгээнэ.


Санамж: Гэрээ хэрэгжиж эхэлснээс гэрээний хугацаа дуусталх хугацаанд энэ журмын 7.4-т заасан мэдээллүүд өөрчлөгдөхгүй.

7.5. Энэ журмын 5.1.2-т заасан даатгуулагчийн цахимаар гаргасан хүсэлтийг нийгмийн даатгалын нэг байгууллагад төвлөрүүлэн хүлээн авч үйлчилгээ үзүүлж болно.

7.6. Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах гэрээг цахимаар байгуулах, гэрээгээ сунгах үйлчилгээг цахимаар авсан иргэний гэрээ (нэмэлт гэрээ)-г нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) хэвлэн авч холбогдох албан тушаалтнаар хянуулан баталгаажуулж, гарын үсгээ зурж хадгалах бөгөөд даатгуулагчийг биеэр ирсэн үед нь гарын үсгийг нь зуруулна.

7.7. Иргэн болон нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь хууль тогтоомжийн дагуу олгогдсон тоон гарын үсгийг ашиглан гэрээг баталгаажуулж болно.

7.8. Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь сайн дураар даатгуулагчийн хүсэлт хэрэгжсэн, шимтгэлийн төлбөр төлөгдсөн, энэ журмын 10.1.3, 10.1.4-т заасны дагуу гэрээнд өөрчлөлт орох шаардлага гарсан, даатгуулагчийн гэрээний хугацаа дууссан, гэрээний үүргээ хэрэгжүүлээгүйгээс эрсдэлд орох нөхцөл байдал үүссэн зэрэг тохиолдолд мэдэгдэл, сануулга өгөх үйлчилгээг цахимаар болон бусад хэлбэрээр хүргэнэ.



Найм. Даатгуулагчийн шимтгэл ногдуулан төлөх сарын хөдөлмөрийн хөлс, орлогын хэмжээ, шимтгэл төлөх хувь хэмжээ, хугацаа

8.1. Даатгуулагч шимтгэл ногдуулан төлөх сарын хөдөлмөрийн хөлс, орлогын хэмжээг өөрөө тодорхойлон энэ журмын 6.1, 6.2-т заасан гэрээнд тусгана.

8.2. Нийгмийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулж буй энэ журмын 5.1-д заасан даатгуулагчийн өөрөө мэдүүлсэн шимтгэл төлөх сарын хөдөлмөрийн хөлс, орлогын хэмжээ нь тухайн үед хүчин төгөлдөр мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.


8.3. Гэрээний хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны шийдвэрээр шинэчлэн тогтоосон тохиолдолд уг шийдвэрийг хэрэгжих хугацаанаас нь эхлэн дагаж мөрдөнө.

8.4. Энэ журмын 6.1, 6.2-т заасан гэрээнд уг гэрээний үргэлжлэх хугацаа, шимтгэл төлөхөөр даатгуулагч өөрөө тодорхойлсон сарын хөдөлмөрийн хөлс, орлогын хэмжээ, түүнээс тооцон сар бүр төлөх шимтгэлийн хэмжээг заавал тусгасан байна.

8.5. Энэ журмын 5.1.1, 5.1.2-т заасан даатгуулагч нь өөрөө тодорхойлсон сарын хөдөлмөрийн хөлс, орлогоос Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт заасан хувь хэмжээгээр тооцсон нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр төлөх үүрэг хүлээх бөгөөд мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.6-д заасны дагуу сар, улирал, хагас жил, жилээр урьдчилан төлж болно.

8.6. Даатгуулагч нь энэ журмын 8.5-д заасан хувь хэмжээгээр тооцсон сайн дурын даатгалын шимтгэлийн төлбөрийг харьяалах нийгмийн даатгалын байгууллагын нийгмийн даатгалын сангийн харилцах дансанд төлөх бөгөөд уг төлбөрийг банкинд бэлэн бус хэлбэрээр эсхүл интернет, гар утасны аппликейшн, Qrau зэрэг цахим үйлчилгээг ашиглан төлж болно.

8.7. Энэ журмын 5.1.3, 5.1.4-т заасан даатгуулагч эх нь Засгийн газрын 1994 оны 212 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан журмын 2-ын "в^{1/н}", "в^{2/н}"-д заасны дагуу шимтгэл төлөх үед мөрдөж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож, хүүхдээ 3 нас хүртэл асрах чөлөөтэй байх хугацаанд шимтгэл төлөх хүсэлт гаргасан бол тэдгээрийн шимтгэлийг Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгалд, 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хувь хэмжээгээр тооцно. Ийнхүү тооцсон сард төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг тухайн эх өөрөө төлсөн тохиолдолд, нийгмийн даатгалын байгууллага нь үлдэх 50 хувийг нь сар бүр тэтгэмжийн даатгалын сангаас болон улсын төсвөөс нэхэмжлэн авч холбогдох даатгалын сангийн харилцах дансанд шилжүүлэн төлнө.



Сайн дурын даатгуулагч эхийн төлөх шимтгэлийн тооцоо

№	Шимтгэл төлөх даатгалын сангийн төрөл	Шимтгэл төлөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ	Шимтгэл төлөх хувь	Сард төлбөл зохих шимтгэлийн дүн (1*2)	Үүнээс	
					Эхийн өөрөө төлөх шимтгэлийн дүн (3*50%)	Тэтгэмжийн даатгалын сангаас болон улсын төсвөөс хариуцан төлөх шимтгэлийн дүн (3*50%)
А	Б	1	2	3	5	6
1	Тэтгэврийн даатгал	420000	11.5*	48300	24150	24150
2	Тэтгэмжийн даатгал		1.0*	4200	2100	2100
Бүгд		420000	12.5*	52500	26250	26250


(Тайлбар: Төлөх шимтгэлийн тооцоог 2020 оны хүчин төгөлдөр мөрдөж буй эрх зүйн хүрээнд тооцов.)

Санамж: Сайн дурын даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон төлөх даатгуулагч эхийн тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын санд төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг тухайн эх өөрөө хариуцан төлсөн нөхцөлд нийгмийн даатгалын байгууллага нь үлдсэн 50 хувийг энэ журмын 5.1.3-т заасан даатгуулагч эхийн хувьд тэтгэмжийн даатгалын сангаас, 5.1.4-т заасан даатгуулагч эхийн хувьд улсын төсвөөс тус тус нэхэмжлэн авч тухайн даатгуулагч эхийн нэр дээр бүртгэн тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын сангийн харилцах дансанд шилжүүлэн төлнө.

8.8. Энэ журмын 5.1.3, 5.1.4-т заасан даатгуулагч эх нь Засгийн газрын 1994 оны 212 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан журмын 2-ын "в^{3/}"-д заасны дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш хөдөлмөрийн хөлс, орлогоос шимтгэл тооцон төлөхөөр хүсэлт гаргасан бол уг орлогод ногдох тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд төлөх шимтгэлийг Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгалд, 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хувиар тооцно. Ийнхүү тооцсон төлбөл зохих шимтгэлийн тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын санд төлөх шимтгэлийн дүн тус бүрээс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг харгалзан хасч үлдэх зөрүү шимтгэлийн дүн дээр үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд төлөх шимтгэлийг нэмж тооцон тухайн эх өөрөө хариуцаж нийгмийн даатгалын сангийн харилцах дансанд төлнө. Энэ тохиолдолд нийгмийн даатгалын байгууллага нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын санд төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас болон улсын төсвөөс нэхэмжлэн авч тухайн даатгуулагч эхийн нэр дээр бүртгэн холбогдох даатгалын сангийн харилцах дансанд шилжүүлэн төлнө.

Сайн дурын даатгуулагч эхийн төлөх шимтгэлийн тооцоо

№	Шимтгэл төлөх даатгалын сангийн төрөл	Шимтгэл төлөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ	Шимтгэл төлөх хувь	Сард төлбөл зохих нийт шимтгэлийн дүн (1*2)	Үүнээс	
					Эхийн өөрөө төлөх шимтгэлийн дүн (3-5)	Тэтгэмжийн даатгалын сангаас болон улсын төсвөөс хариуцан төлөх шимтгэлийн дүн ((ххдх*2)*50%)
А	Б	1	2	3	4	5





1	Тэтгэврийн даатгал	800000	11.5*	92000	67850	24150
2	Тэтгэмжийн даатгал		1.0*	8000	5900	2100
3	ҮОМШӨ-ний даатгал		1.0*	8000	8000	-
Бүгд		800000	13.5*	108000	81750	26250

(Тайлбар: Төлөх шимтгэлийн тооцоог 2020 оны хүчин төгөлдөр мөрдөж буй эрх зүйн хүрээнд тооцов.)

Санамж: Сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш хөдөлмөрийн хөлс, орлогоос тооцож сайн дураар даатгуулсан эхийн тухайн сард төлөх шимтгэлийг тодорхойлохдоо тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын санд төлөх нийт шимтгэлээс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг нь харгалзан хассан зөрүү дээр үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд төлөх шимтгэлийг нэмж тухайн эхийн өөрөө хариуцаж төлөх нийт шимтгэлийн дүнг гаргана. Энэхүү дүнг гэрээнд нь тодорхой тусгана.

Даатгуулагч эх нь өөрийн хариуцан төлөх шимтгэлийг нийгмийн даатгалын санд төлсөн тохиолдолд нийгмийн даатгалын байгууллага нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын санд төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг энэ журмын 5.1.3-т заасан даатгуулагч эхийн хувьд тэтгэмжийн даатгалын сангаас, 5.1.4-т заасан даатгуулагч эхийн хувьд улсын төсвөөс тус тус нэхэмжлэн авч тухайн даатгуулагч эхийн нэр дээр бүртгэн тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын сангийн харилцах дансанд шилжүүлэн төлнө.


Ес. Шимтгэл төлөлтийн тооцоог мэдээллийн санд бүртгэх, илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох, нийгмийн даатгалын дэвтэрт бичиж баталгаажуулах

9.1. Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах гэрээ байгуулах хүсэлт гаргасан даатгуулагч "иргэн"-ийг нийгмийн даатгалын сангийн харилцах дансанд шимтгэлээ төлсөн сараас гэрээг нь хэрэгжсэнд тооцож, нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь шимтгэл төлөлтийн мэдээллийг мэдээллийн цахим санд үнэн зөв бүртгэж баталгаажуулна. Энэхүү заалтад гэрээг сунгах хүсэлт мөн адил хамаарна.

9.2. Сайн дураар даатгуулагч нь гэрээний хугацаанд албан журмаар даатгуулж, давхар шимтгэл төлсөн тохиолдолд нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь давхардуулан төлсөн шимтгэл төлөлтийн тооцоог хийж, цаашид албан журмын даатгалын харилцааг үргэлжлүүлэн шимтгэл төлөх бол сайн дурын даатгалд төлсөн шимтгэлийг буцаан олгох, хэрэв сайн дурын даатгалын харилцааг үргэлжлүүлэн шимтгэл төлөх бол давхардуулан төлсөн сайн дурын даатгалын шимтгэлийг албан журмын даатгалын шимтгэл төлсөн сарын дараагийн сард шилжүүлж тооцож болно.

9.3. Энэ журмын 5.1.3, 5.1.4-т заасан даатгуулагч эхийн хувьд энэ журмын 9.2-т заасан арга хэмжээг мөн адил авах бөгөөд төлсөн шимтгэлийг нь буцаан олгох тохиолдолд тэтгэмжийн даатгалын сангаас болон улсын төсвөөс хариуцан төлсөн шимтгэлийг холбогдох санд буцаан шилжүүлж, тооцоог дуусгавар болгоно.

9.4. Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь даатгуулагчийн шимтгэл төлөлтийн мэдээллийг гэрээ, түүний дугаар, эхэлсэн болон дуусгавар болсон огноо, сарын орлого, банкны цахим хуулга, орлогын мэдүүлгийн баримтыг тус тус үндэслэн



мэдээллийн цахим санд бүртгэж, нийгмийн даатгалын дэвтэрт бичиж гарын үсэг зурж, тэмдгээр баталгаажуулна.

9.5. Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь энэ журмын 5.1.3, 5.1.4-т заасан даатгуулагч эх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож шимтгэл төлсөн бол уг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр, түүнчлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш орлогоос тооцож шимтгэл төлсөн бол уг шимтгэл төлсөн орлогын хэмжээгээр нийгмийн даатгалын дэвтэрт бичиж баталгаажуулна.

9.6. Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь гэрээний хугацаанд засаг захиргааны харьяаллын дагуу нийгмийн даатгалын байгууллага хооронд шилжих хүсэлт гаргасан даатгуулагчийн шилжих хүртэлх хугацааны шимтгэл төлөлтийн тооцоог бүрэн хийж дуусгасны дараа шилжих хүсэлтийг шийдвэрлэж, хувийн хэрэг, холбогдох баримт бичгийг архивт хадгална.

9.7. Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь энэ журмын 9.6-д заасны дагуу шилжиж ирсэн даатгуулагчийн гэрээнд тусгагдсан мэдээлэл, шимтгэл төлөлтийн тооцоог нягтлан шалгасны дараа түүнийг өмнөх гэрээний дугаараар нь мэдээллийн цахим санд бүртгэж, уг гэрээнд заасан нөхцөлөөр нь шимтгэлийг үргэлжлүүлэн төлүүлж, хувийн хэрэг нээж тооцоог хийнэ.

9.8. Энэ журмын 9.6, 9.7-д заасан шилжүүлэх, шилжүүлэн авах үйлчилгээг цахимаар үзүүлж болно.

Арав. Даатгуулагчийн шимтгэл ногдуулан төлж буй сарын хөдөлмөрийн хөлс, орлогын хэмжээ, шимтгэл төлөх хувь хэмжээ, хугацаанд өөрчлөлт оруулах


10.1. Гэрээний хугацаанд даатгуулагчийн шимтгэл ногдуулан төлж буй сарын хөдөлмөрийн хөлс, орлогын хэмжээг өөрчлөхгүй бөгөөд дараах тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулж, нэмэлт гэрээ байгуулна:

10.1.1. Энэ журмын 5.1.1, 5.1.2-т заасан даатгуулагч, энэ журмын 12.1-д заасны дагуу шимтгэлийн төлбөрөө бүрэн төлж, гэрээг сунгах хүсэлт гаргасан тохиолдолд нэмэлт гэрээ байгуулна. Нэмэлт гэрээнд өмнөх гэрээнд заасан шимтгэл ногдуулан төлж байгаа сарын хөдөлмөрийн хөлс, орлогын хэмжээ, гэрээний үргэлжлэх хугацаа болон ажил эрхлэлтийн байдалд өөрчлөлт оруулж болно.

10.1.2. Энэ журмын 5.1.3, 5.1.4-т заасан даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс орлогын хэмжээг гэрээ байгуулснаас хойш 12 сар тутамд нэг удаа өөрчилж болно.

10.1.3. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны шийдвэрээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд зөвхөн шинээр батлагдсан хэмжээнээс доош дүнгээр орлогоо тодорхойлсон даатгуулагчдын орлогыг уг шийдвэр хэрэгжиж эхлэх хугацаанаас эхлэн шинээр батлагдсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр өөрчилнө.

10.1.4. Хууль тогтоомжид өөрчлөлт орж, энэ журмын 8.5-д заасан шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд уг хувь хэмжээ хэрэгжиж эхлэх хугацаанаас эхлэн төлөх шимтгэлийн хэмжээг өөрчлөгдсөн хувиар тооцно.



**Арван нэг. Сайн дураар даатгуулсан тухай гэрээ байгуулахад
бүрдүүлэх баримт бичиг**

11.1. Энэ журмын 5.1-д заасан даатгуулагч нь нийгмийн даатгалын хэлтэс (байцаагч) дээр биеэр ирж гэрээ байгуулах тохиолдолд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

- 11.1.1. Иргэний үнэмлэх;
- 11.1.2. Нийгмийн даатгалын дэвтэр (байхгүй бол шинээр нээлгэнэ);
- 11.1.3. Зураг 1% (нийгмийн даатгалын дэвтэр шинээр нээлгэх бол);
- 11.1.4. Энэ журмын 5.1.3, 5.1.4-т заасан даатгуулагч эхийн хувьд хүүхдийн төрсний гэрчилгээ.

11.2. Иргэнд үзүүлэх үйлчилгээг цахимжуулах зориулалтаар энэ журмын 11.1.1, 11.1.4-т заасан баримт бичгийн мэдээллийг холбогдох эрх зүйн хүрээнд төрийн байгууллагын мэдээллийн сангаас цахимаар авч ашиглаж болно.

**Арван хоёр. Гэрээний хугацааг сунгах, дуусгавар болгох, цуцлах,
хүчингүйд тооцох**

12.1. Даатгуулагч гэрээнд заасан төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлээ сангийн харилцах дансанд бүрэн төлж дууссан тохиолдолд гэрээний хугацааг сунгуулах тухай хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-д өөрийн биеэр эсхүл цахимаар гаргаж болно. Сунгасан гэрээний эхний сарын шимтгэлийг төлсөн хугацаанаас хамааран сунгалтын хүсэлт нь дараах байдлаар хэрэгжинэ:

12.1.1. Өмнөх гэрээний хугацаа дууссан сарын дараагийн сард багтаан нийгмийн даатгалын санд шимтгэл төлж, гэрээгээ сунгах хүсэлт гаргасан даатгуулагчийн гэрээг үргэлжлүүлэн сунгасанд тооцно.

12.1.2. Гэрээний хугацааг сунгуулах хүсэлт гаргасан боловч өмнөх гэрээ дууссанаас хойш 1 ба түүнээс дээш сарын дараа нийгмийн даатгалын санд шимтгэл төлсөн тохиолдолд шимтгэл төлөөгүй саруудыг алгасч, уг хугацаанд даатгалын харилцааг тасарсанд тооцох бөгөөд шимтгэл төлсөн сараас нь сунгасанд тооцно.

12.1.3. Энэ гэрээний 12.1.1, 12.1.2-т заасны дагуу шимтгэлээ төлсөн сараас гэрээний хугацааны сунгалтыг хэрэгжсэнд тооцож, нэмэлт гэрээ байгуулан гарын үсэг зурж баталгаажуулна.

12.1.4. Нэмэлт гэрээнд энэхүү гэрээний 10.1.1-д заасан мэдээллийг өөрчлөгдсөн эсэхээс нь үл хамааран заавал тусгана.

12.2. Даатгуулагчийн гэрээний хугацаа дараах тохиолдолд дуусгавар болно:


12.2.1. Даатгуулагчийн гэрээний хугацаа дууссан боловч гэрээг сунгах хүсэлт гаргаагүй бол гэрээний хугацаа дууссан сарын дараагийн сараас;

12.2.2. Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон сараас ;

12.2.3. Нас барсан сараас;

12.2.4. Энэ журмын 5.1.3, 5.1.4-т заасан даатгуулагч эхийн асарч байгаа хүүхэд нь 3 насанд хүрсний дараагийн сараас;

12.2.5. Даатгуулагч эхийн асарч байгаа хүүхэд нь 3 нас хүрээгүй байхдаа бусдад үрчлэгдсэн, эсхүл нас барсан бол түүний дараагийн сараас;



12.2.6. Даатгуулагч сайн дурын даатгалын гэрээний хугацаанд уг гэрээг дуустал хугацаагаар Иргэний болон Хөдөлмөрийн тухай хуулийн гэрээ байгуулж ажил хөдөлмөр эрхэлсэн бол тухайн сараас.

12.3. Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах гэрээг дараах тохиолдолд хүчингүйд тооцно:

12.3.1. Шимтгэл төлж гэрээ байгуулснаас өмнөх саруудын шимтгэлийг нөхөн төлсөн нь баримтаар нотлогдсон бол;

12.3.2. Гэрээг хуурамчаар үйлдсэн нь шалгалтаар тогтоогдсон бол;

12.3.3. Гэрээг 2 талын аль нэг нь зөвшөөрөөгүй бол;

12.3.4. Гэрээ байгуулсан боловч гэрээний хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлээ төлөөгүй бол хамгийн сүүлд шимтгэл төлсөн сарын дараагийн сарын 1-ний өдрөөс.

Арван гурав. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих

13.1. Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах гэрээний үндэслэл, баталгаажуулалт, гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт, шимтгэл төлөлт зэрэгт аймаг (дүүрэг)-ийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга, холбогдох тасгийн дарга хяналт тавина.

13.2. Аймаг (дүүрэг)-ийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын шийдвэрээр суманд ажиллах албан тушаалтан сумын нийгмийн даатгалын байцаагчийн даатгуулагчтай байгуулсан гэрээг хянаж, гэрээний “Хянаж баталгаажуулсан” гэсэн хэсэгт гарын үсэг, албан тушаал, он, сар, өдрийг тэмдэглэн баталгаажуулалт хийнэ.

13.3. Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь энэ журмын 5.1-д заасан даатгуулагчийн шимтгэл төлөлтийн сарын тооцоог хийж тайланг гаргахын өмнө доор дурдсан холбогдох асуудлуудын үндэслэлийг нягтлан шалгаж шийдвэрлэсэн байна:

13.3.1. Тухайн даатгуулагчтай байгуулсан гэрээ нь эрх зүйн үндэслэлтэй эсэх;

13.3.2. Гэрээнд тусгагдсан шимтгэлийн тооцооны мэдээллийг цахим санд бүрэн оруулж бүртгэж, баталгаажуулсан эсэх;

13.3.3. Гэрээний хугацаа сунгагдсан, дуусгавар болоогүй байгаа эсэх;

13.3.4. Гэрээгээр тохиролцсон шимтгэлийг хугацаанд нь төлүүлэх талаар тухайн даатгуулагчид урьдчилан мэдэгдэх, сануулах арга хэмжээ авсан эсэх;


13.3.5. Нийгмийн даатгалын сангийн харилцах дансанд төлсөн шимтгэл нь тухайн даатгуулагч болон хүүхдээ асарч байгаа эхийн овог, нэр, регистрийн дугаараар бүртгэгдсэн эсэх;

13.3.6. Гэрээнд заасан хугацаанд шимтгэлээ бүрэн төлсөн эсэх;

13.3.7. Асарч байгаа хүүхэд нь 3 насанд хүрсэн эсэх;

13.3.8. Асарч байгаа хүүхдээ 3 нас хүрээгүй байхад нь бусдад үрчлүүлсэн, эсхүл нас барсан эсэх;

13.3.9. Сайн дурын даатгалын гэрээний хугацаанд албан журмын даатгалд даатгуулж, давхар хөдөлмөрийн хөлс, орлого авч шимтгэл төлсөн тохиолдолд тооцооллыг зөв хийсэн эсэх, шийдвэрлэсэн эрх зүйн үндэслэл;



13.3.10. Хөдөлмөрийн хөлс, орлого, төлсөн шимтгэлийн дүн болон байгуулсан гэрээний он, сар, өдөр, дугаарыг нийгмийн даатгалын дэвтэрт бичиж баталгаажуулсан эсэх.

13.4. Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь даатгуулагчийн илүү болон дутуу төлсөн шимтгэлийн тооцоог энэ журмын 13.3-т заасны дагуу хийж, тайлан, массивыг хагас, бүтэн жилээр гарган нэгтгэж, эрх бүхий ажилтнаар баталгаажуулан нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайланд хавсаргана.

13.5. Нийгмийн даатгалын байцаагч даатгуулагчийн шимтгэл төлөлтийн массив, жагсаалтыг жилээр хэвлэн эрх бүхий ажилтнаар баталгаажуулан, архивын нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгнө.

Арван дөрөв. Маргаан шийдвэрлэх

14.1. Энэ журмыг хэрэгжүүлэхтэй холбогдсон маргаантай асуудлыг хоёр тал харилцан зөвшилцөн шийдвэрлэх зарчим баримтлах бөгөөд шаардлагатай гэж үзвэл Гомдлын шаардлагын зөвлөл болон шүүхээр шийдвэрлүүлнэ.

Арван тав. Нийгмийн даатгалын тухай хууль болон энэхүү журмыг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

15.1. Энэ журмын 5.1-д заасан даатгуулагч шимтгэлээ хугацаандаа төлөөгүй, эсхүл дутуу төлсөн тохиолдолд Нийгмийн даатгалын тухай, Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

